

АГУУЛГА

ОРШИЛ	1
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	9
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	9
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	11
5.3. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	11
5.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	11
5.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.6. Тэрбум мод төслийн хүрээнд	13
5.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13
5.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	14
5.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	14
5.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	15
5.11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15
ДҮТНЭЛТ	17

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
Хүснэгт №2. Төслийн талбайн байршлын солбилцол	2
Хүснэгт №3. Үйлдвэрлэлийн нөөц	3
Хүснэгт №4. Ашиглалтын технологи	3
Хүснэгт №5. Ил уурхайн процесс	4
Хүснэгт №6. Ил уурхайн хөрс хуулалтанд ажиллах экскаваторын техникийн үзүүлэлт	4
Хүснэгт №7. Баяжуулах цехийн бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө	5
Хүснэгт №8. Угаах процесст зарцуулахлагдах усны хэрэглээ	5
Хүснэгт №9. Болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	8
Хүснэгт №10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
Хүснэгт №11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	11
Хүснэгт №12. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт №13. Тэрбум мод тарих төслийн хүрээнд тарих модны тоо, зардал	13
Хүснэгт №14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13
Хүснэгт №15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт №16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	14
Хүснэгт №17. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	15
Хүснэгт №18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	16
Хүснэгт №19. 2025 оны БОМТ-ний нийт зардал	17

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хагаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг буурцуулах, арилгах, урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөргө үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөн нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах зүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Ирмүүн босго” ХХК нь мөрдөж ажиллана.

Хайлаастын дэнжийн ХШ-45-75 хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхийл сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдснөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ боловсруулах ара аргачлал:

“Ирмүүн босго” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлаастын дэнжийн ХШ-45-75 хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл нь өмнөх жилүүдэд бүрэн хүчин чадлаар ажиллаж чадаагүй, ордын нөөцийг бүрэн ашиглаж дуусаагүй байгаа тул 2025 онд уурхайн хаалт хийгдэхгүй. Иймд төслийн БОННҮ-ний тайлангийн хаалтын өмнөх жилийн менежментийн төлөвлөгөөг урталь болгон 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тус төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Ирмүүн босго” ХХК-ийн хэрэгжүүлэх Хайлаастын дэнжийн ХШ-45-75 хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны БОМТ-нд нийт 74.78 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Аж ахуйн нэгжийн нэр	“Ирмүүн босго” ХХК
1	Улсын бүртгэлийн дугаар	9011487107
2	Регистрийн дугаар	5849314
3	Төслийн нэр	Хайлаастын дэнжийн ХШ-45-75 хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
4	Төслийн байршил аж ахуйн нэгжийн хаяг	Төв аймаг Заамар сумын нутаг
5	Захирлын мэдээлэл	Х. Цогоо

Үйлдвэрлэх бүтээгдэхүүн: Алт

Төслийн хүчин чадал, үргэлжлэх хугацаа

2025 оны 6-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж хайлаастын дэнжийн хэсгийн уурхайд өмнөх онд ашигласан техник тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд ордын үлдсэн нөөц болох 3.5 мян.м³ алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

Ашиглалтын технологи

Тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ил аргаар ашиглана.

Төслийн байршил

Орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Заамар сумын нутагт харьялагддаг бөгөөд MV-020868 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл бүхий талбайд Улаанбаатар хотоос баруун хойш 220км, Заамар сумын төвөөс баруун хойд зүгт 25км-т байрзүйн зургийн М-48-126, 138 нэрэлбэрт оршино.

Хүснэгт №2. Төслийн талбайн байришины солбицол

Цэгийн дугаар	Үртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	104°	32'	54.51"	48°	19'	55.83"
2	104°	32'	54.57"	48°	19'	50.17"
3	104°	33'	6.71"	48°	19'	50.21"
4	104°	33'	6.75"	48°	19'	43.74"
5	104°	33'	16.46"	48°	19'	43.77"
6	104°	33'	16.51"	48°	19'	38.11"
7	104°	33'	26.22"	48°	19'	38.15"
8	104°	33'	26.29"	48°	19'	30.05"
9	104°	33'	33.57"	48°	19'	30.08"
10	104°	33'	33.64"	48°	19'	23.61"
11	104°	32'	49.94"	48°	19'	23.45"
12	104°	32'	49.88"	48°	19'	29.91"
13	104°	32'	42.6"	48°	19'	29.89"
14	104°	32'	42.58"	48°	19'	33.13"
15	104°	32'	35.3"	48°	19'	33.1"
16	104°	32'	35.26"	48°	19'	36.33"
17	104°	32'	31.93"	48°	19'	36.33"
18	104°	32'	31.93"	48°	19'	55.73"

Орд ашиглах тусгай зөвшөөрөл

2023.05.24-ний өдөр “Ирмүүн босго” ХХК нь Хайлааст нэртэй MV-020868 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Юбиксолюшн” ХХК-аас шилжүүлэн авсан. Өмнө нь “Бумбат-6” нэртэй 905.35 га талбайг хамардаг байсан байна.

Төв аймаг заамар сумын нутагт орших 81.54 га талбай бүхий ашиг малтмалын MV-020868 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Ирмүүн босго” ХХК-д 2025 оны 10-р сарын 14-ны өдөр хүртэл олгосон.

Уурхайн гадаргуугийн авто зам:

Уурхайг богино хугацаанд ашиглах тул гадаргуугийн технологийн автозам нь байгалийн ердийн хөрсөн зам байна. Дотоод автозамыг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын нэвтрүүлэх болон тээх чадварыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн зайлж хамгийн оновчтой бага байлгах шийдлийг бололцож шулуун схемээр байгуулахаар төлөвлөв. Шулуун схемийг ашигт малтмалын хэвтээ болон бага уналттай давхаргыг ашиглахад хэрэглэхэд тохиромжтой.

Хүснэгт №3. Үйлдвэрлэлийн нөөц

№	Блокийн дугаар	Ил уурхайгаас нэмэгдэх хөрсний хэмжээ	Үйлдвэрлэлийн нөөц				Бүтээгдэхүүн гаргалт			
			Хөрсний хэмжээ	Элсний хэмжээ	Дундаж агуулга	Алтны нөөц, кг	Металл авалт	Алтны хэмжээ, кг		
			мян.м ³	мян.м ³	мян.м ³	мг/м ³	шлих	цэвэр	%	
Эдийн засгийн үр ашигтай нөөц										
1	5-B'	6.47	53.6	17.0	547	9.28	8.43	92.6	8.59	7.81
2	6-B'	1.69	7.9	1.5	786	1.14	1.02	92.6	1.06	0.94
3	7-B'	1.27	8.7	3.5	425	1.50	1.34	92.6	1.39	1.24
Бүгд		9.44	70.16	21.96	543	11.92	10.79	92.6	11.04	9.99
Тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай нөөц										
4	IV-B'	10.59	34.6	0.9	1615	1.42	1.27	92.6	1.31	1.18
5	V-B'	1.68	11.1	2.5	80	0.20	0.17	92.6	0.19	0.16
Бүгд		12.27	45.74	3.38	480	1.62	1.44	92.6	1.50	1.33
Нийт		21.71	115.90	25.34	534	13.54	12.23	92.6	12.54	11.32

2025 онд үлдсэн 7-В' блокийн нөөцийг бүрэн ашиглана. Нийт 8.7 мян.м³ хөрс хуулж, дунджаар 425 мг/м³ агуулгатай 3.5 мян.м³ элс олборлон баяжуулж 1.24 кг алт /химийн цэврээр/ гарган борлуулахаар байна.

Орд ашиглах технологи: Ордын ашигт давхаргын алтны /дундаж агуулга/ тархац суналын дагуу харьцангуй жигд тогтвортой, хучаас хурдас, алттай давхаргын зузаан харьцангуй жигд үзүүлэлттэй, Ш бүлгийн том хэмжээний ангиллын ордод хамаарна. Орд нь цэвдэгшилгүй, ашигт давхарга нь дунджаар 9.7 м-ийн гүнд /3.5-13.2м-ийн хооронд/, усгүй хуурай, гидрогеологийн тааламжтай нөхцөлд байршина. Ашигт давхаргын хил зааг тод ялгагддаг, ордыг ил аргаар угаах төхөөрөмжийн тусlamжтайгаар ангилан олборлох технологиор олборлоход тохиромжтой байна.

Энэ ордын нөөцийн хэсэглэлийн хамгийн бага өргөн 20 метр нь ордыг ил аргаар ашиглах үеийн уул техникийн шаардлагыг хангаж байна.

Хүснэгт №4. Ашиглалтын технологи

Технологи	Систем	Үндсэн ажил	Технологийн процессууд
Ил уурхайгаар ашиглах	Авто тээвэртэй ашиглалтын систем	Хөрс хуулалт	• Бульдозероор турэх
			• Ухах
			• Ачих
			• Тээвэрлэх
			• Гадаад овоолго
		Элс олборлолт	• Дотоод овоолго
			• Ухах
			• Ачих
			• Тээвэрлэх

Ажиллах горим: Тус уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд баяр ёслолын болон амралтын үед ажилчдын амрах хугацааг МҮ-ын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу болон уурхайн даргын тушаалаар зохицуулна. Мөн бүс нутгийн цаг агаарын онцлог, уул тээврийн тоног төхөөрөмжүүдийн ажлын бэлэн байдал, тэдгээрийн техникийн нөхцөл боломжуудаас хамааран улирлын чанартай ажиллах тул 2025 онд 6-р сарын 1-ээс эхлэн бэлтгэл ажлыг

хангаж, амралт, баяр ёслол, засвар үйлчилгээний сүл зогсолтоо тооцоод нийт 30 хоногийн хугацаанд ажиллахаар тооцоолсон байна.

Ил уурхайн хүчин чадал: 2025 оны 6-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж. Хайлаастын дэнжийн хэсгийн уурхайд өмнөх онд ашигласан техник, тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд ордын үлдсэн нөөц болох 3.5 мян.м³ алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана. Мөн тухайн онд хаалт нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлнэ.

Уурхайн бусад тээвэр: Уурхайн бусад ажил болон аж ахуйн хэрэгцээнд зориулж инженер техникийн ачааны машин, тоног төхөөрөмжийн түлшний машин, зам талбайн усалгааны ташин зэрэг тээврийн тоног төхөөрөмжүүдийг ашиглана.

Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж: Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа техник, тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан үргэлжлүүлэн ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан 2025 оны бүтээлийн тооцоог гүйцэтгэв.

Ил уурхайн үндсэн технологийн процесс нь өнгөн хөрсийг бульдозероор хуулж овоолгод байршуулах, хөрсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж гадаад болон дотоод овоолгод байршуулах, алттай элсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж баяжуулах үйлдвэрийн хажууд овоолгод байршууна.

Уурхайн төлөвлөлтийн үндсэн шийдлүүд:

- ✓ 2025 оны уулын ажлыг зураг төсөлд төлөвлөсний дагуу явуулах бөгөөд угаах төхөөрөмж, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн бэлтгэл ажил бүрэн хангагдсан.
- ✓ Ашиглалтын эхнээс хөрсний дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийг уулын ажилтай хамт явуулахаар төлөвлөсөн

Хүснэгт №5. Ил уурхайн процесс

Ажил	Процессууд/ тоног төхөөрөмж			
Хөрс хуулалт	Ухаж ачихад бэлтгэх	Ухаж ачих	Тээвэрлэлт	Овоолго
	Бульдозер	Экскаватор	Автосамосвал	Бульдозер
Олборлолт	-	Ухаж ачих	Тээвэрлэлт	-
	-	Экскаватор	Автосамосвал	-

Ухаж ачих процесс

Талбайн үржил шимт хөрсийг хуулсны дараа 7-B' блокийн хөрсний чuluулгийг экскаватороор хуулан өмнөх ашиглалтын үед үсгэсэн хоосон орон зайд экскаватор- автосамосвалын хослолоор дотоод овоолго хийх замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Хөрс хуулалтын ажлын догол мөргөцгийн өндөр нь ажиллах тоног төхөөрөмжийн үзүүлэлтээс шалтгаалан 4 м байна.

Хүснэгт №6. Ил уурхайн хөрс хуулалтанд ажиллах экскаваторын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт	Зураг
			DOOSAN DX500	
1	Утгуурын багтаамж	м ³	3.2	
2	Утгалтын хамгийн их радиус	м	10.8	
3	Утгалтын хамгийн их гүн	м	7.3	
4	Ачих хамгийн их өндөр	м	7.2	
5	Явах хамгийн их хурд	км/цаг	5.6	
6	Явах ангийн урт	м	5.4	
7	Явах ангийн өргөн	м	3.9	
8	Их бисений өндөр	м	3.4	
9	Явах ангийн гинжний өргөн	м	0.6	
10	Хөдөлгүүрийн чадал	кВт	238	
11	Жин	тн	48.4	
12	Түлш зарцуулалт	л/цаг	30	

Овоолох процесс

Шимт хөрсийг хуулахаа хайгуулын шугамын дагуу баруун урдаас зүүн хойд зүгт бульдозероор 0.3 м-ийн зузаанаар хуулан түрж, уурхайн зүүн хойно овоолно. Шимт хөрсний

овоолгыг 3 м өндөрөөр байгуулж, ашиглалтын явцад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) тухайн жил бүрд хамаарах блокуудыг шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай зэрэг гүйцэтгэх боломжтой байхаар төлөвлөсөн.

Уулын ажлаар 2025 онд хуулагдах нийт хөрсний хэмжээ 8.7 мян.м^3 бөгөөд хөрсний сийрэгжилтийг 1.15 гэж үзвэл нийт 10.0 мян.м^3 болж байна. Энэ онд ордын уул-техникийн нөхцөл, ашиглах дараалал нь уурхайн овоолгын аж ахуйг дотоод схемээр зохион байгуулах боломж олгож байгаа тул 2025 онд хуулах хөрсийг дотоод овоолгод шилжүүлэн байршуулах мөн 2021 онд үүссэн гадаад овоолгод байгаа 196.7 мян.м^3 хөрсийг дотоод овоолгод шилжүүлэх зэрэг ашиглалтын ажилтай зэрэгцэн техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байна.

Баяжуулалтын технологи

Элс угаан баяжуулах хэсэг нь 2025 онд нийт 3.5 м^3 элс угаан баяжуулах бөгөөд дулааны улирлын 30 хоногт угаалга хийнэ.

Хүснэгт №7. Баяжуулах цехийн бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 онд
1	Угаах элсний хэмжээ	мян.м ³	3.5
2	Угаах элсний дундаж агуулга	мг/м ³	425
3	Металл /химийн цэвэр/	кг	1.34
4	Металл авалт	%	92.6
5	Бүтээгдэхүүн гаргалт /химийн цэвэр/	кг	1.24

Усан хангамж

Технологид шаардлагатай усны хэмжээ: Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 30%-ийг цэвэр усаар сэлбэх ба 70%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м^3 элс угаахад 4 м^3 ус хэрэглэхээр тооцоолов.

Хүснэгт №8. Угаах процесст зарцуулахлагдах усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Нийт уулын ажлын хэмжээ
1	Угаах элсний хэмжээ	мян.м ³	3.50
2	1 м^3 элс угаахад зарцуулах усны хэмжээ	м ³	4
3	Технологит зарцуулах нийт усны хэмжээ	мян.м ³	14.00
	Цэвэр усны хэмжээ 30%	мян.м ³	4.20
	Эргэлтийн усны хэмжээ 70%	мян.м ³	9.8

Хүснэгтээс үзэхэд угаах процесст зарцуулах цэвэр усны хэмжээ 2025 онд 4.2 мян.м^3 байна. Нийт зарцуулагдах усны 70%-ийг эргэлтэнд оруулж 30%-ийг цэвэр усаар сэлбэнэ. Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газрын гадарга, байрзүй: Хэнтийн нуруу ба түүний гол салбаруудын тойрог нь Хэнтийн гол нуруу, Бага Хэнтий, Их Хэнтийн нуруу, тэдгээрийн томоохон салбаруудыг багтаанаа. Эндхийн үнэмлэхүй өндөр нь 2000-2500 метр бөгөөд хамгийн өндөр цэг нь Асралт Хайрхан юм. Хэнтийн нурууд ялангуяа Бага Хэнтийн нурууны хажуу нь хоорондоо адилгүй, хойт хажуу нь маш эгц бөгөөд урт, харин өмнө хажуу нь нилээн налуувтар болно. Гэвч хөёулаа нураг асгаар бүрхээстэй байна. Хажуугийн дээд хэсэгт шаталсан хэдэн дэнж тодорхой үзэгдэнэ.

Тойргийн хилийг тоймлон заавал: Зүүн талд Барах голын адаг орчмоор гарч өмнө хэсэгтээ Хурах, Туул голыг дагасан тектоникийн гаралтай хөндийнүүд болон Улаанбаатар хотоос нилээн хойгуур гарах ба баруун гар талдаа Хараа голын баруун гарын цутгалуудыг огтлон гарсан шугам, хойт талд улсын хил болно.

Голын хөндийнүүд хэдэн янзын дүрс хэлбэртэй юм. Гол нуруудын хөндий их төлөв нарийхан хавцлын байдалтай юм. Үүний зэрэгцээгээр тэнд бас хэдэн зуугаад метр өргөн хөндий ч бий. Тэр хөндийнүүдээр эртний мөсөн гол урсан бууж байсны оп мөр болох морены дов толгод, далан, дэнж, хаагдсан нуур тохиолдоно. Хэнтийн гол нуруудын захаар байгаа хөндийнүүд 1-3 км өргөн, хажуунууд мөн эгц болоод асгаар бүрхээстэй байна.

Энэ тойрог чийг тунадас ихтэй учраас намаг ихтэй, гол горхиуд усаар элбэг, уналт их, урсгал түргэн байдаг.

Ур амьсгалын онцлог. Төслийн талбай орчимд зуны улиралд эх газрын дулаан хуурай агаар зохнилдог. Иймээс орох хур тунадас ихэнхдээ аадар шинжтэй байдаг. Намар хур тунадас багасаж, цочир хүйтрэлт 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр ажиглагдсан 10 дугаар сарын сүүлч, 11 дүгээр сарын эхээр өвлүүн нөхцөлдөө шилжин ордог.

Агаарын температур: Сүүлийн 60 шахам жилд энэ сав газрын агаарын дундаж температур 2.0°C -р дулаарсан байна. Дэлхийн уур амьсгалын дулааралтаар халуун өдрийн давтагдал нэмэгдэхийн хэрээр агаарын өндөр температур сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон байна. Сав газрын бараг бүх цаг уурын станц дээр 1940-өөд оноос хойш тохиолдсон хамгийн өндөр температур сүүлийн хэдхэн жилд тэмдэглэгдсэн байна.

Ур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн манай орны уур амьсгалын эрс тэс байдал, цаг агаарын хүчтэй үзэгдлүүдийн давтагдал нэмэгдсээр байна. Тухайлбал хүснэгт 3-д байгаа агаарын температурын арав 10 жилийн явцаас харахад энэ районд сүүлийн жилүүдэд хүйтний улирлын температур буурч дулааны улирлын температур ихэссэн зүй тогтол ажиглагдаж байна. Харин жилийн дундаж утгаар бол 1992 оноос хойш ялимгүй 0.01°C орчим хэмээр хүйтэрсэн хандлагатай боловч 10 жилийн дунджаас үзэхэд 0.1°C -ээр хүйтэрсэн байна.

Салхи: Салхины хурдны жилийн явцад хавар, намрын улиралд 2 удаагийн максимум утга, өвөл, зуны улиралд 2 удаа минимум утга ажиглагдах бөгөөд хаврынх нь үндсэн их утга байх бөгөөд агаар, хөрс хамгийн хуурай үе, салины хүч хамгийн их үе хоёр давхцахаас болж жилд тохиолддог хүчтэй салхитай болон шороон шуургатай өдрийн тооны гол хувь нь зөвхөн хаврын саруудад тохиолдоно. Энэ районд 2012 оны 06 дугаар сарын 18 нд салхины хурд 26 м/с хүрч салхилж байжээ.

Хур тунадас: Туул голын сав газар Монголдоо ихээхэн чийглэг уур амьсгалтай, жилийн хур тунадасны нийлбэр нь 200-400 мм орчим байдаг. Өндөр уулын буюу гол мөрний урсац бүрдэх бүсэд 350 мм-ээс их хур тунадас жилд ордог бөгөөд хур тунадасны 85-90 орчим хувь нь жилийн дулаан улиралд ордог, хүйтэн улиралд хур тунадас тун бага ордог байдал харагдана. Хур тунадасны горимд дулааны улиралд хур тунадасны дотор аадар борооны эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа юм.

Усан орчин: Төслийн талбай нь Туул голын сав газарт орно. Сав газрын ихэнх нь Хэнтийн уулархаг бүсэд хамаарах ба цутгал голуудын дийлэнх нь Бага Хэнтийн нуруунаас эх аван урсдаг. Туул гол нь байгалийн бүс, бүслүүрийн хувьд эхэн хэсэгтээ уулын тайгын бүс, ойт хээрийн бүсийг дамнан урсах ба Улаанбаатар хотоос доош, сав газрын 80 гаруй хувийг эзлэх хээрийн бүсээр урсаж Орхон голд цутгана. Гол нь эхэн хэсэгтээ эгц хад хясаа болон ой

mod элбэгтэй, уулсын 1-3 км өргөн хөндийтэй ба цаашид голын хөндий өргөссөөр Улаанбаатар хот орчимд 8-10 км болно.

Хөрс: Хөрс газарзүйн хувьд сав газрын хойд хэсэг нь Хэнтийн нурууны төв хэсгийн уулын тундрын болон уулын нутын хөрсний тойрогт, нутгийн дунд болон түүнээс хойш хэсэг нь Хэнтийн нурууны зүүн ба баруун хэсгийн салбар уулсын уулын хар хүрэн ба хээрийн хар хүрэн хөрсний тойрогт, өмнөд хэсэг нь хуурай хээрийн бүсийн ухаа гүвээт, уудам хөндийн хүрэн хөрсний тойрогт ордог.

Төслийн талбай нь гадаргын ерөнхий хэлбэр дүрсийн хувьд орой хэсгээрээ хадархаг нам уулс болон түүний энгэр, бэлийн системийг хамран төслийн талбайн байршил бөгөөд хөрсний үүсвэрийн үйл явцад хажуугийн зөөгдлийн үйл явц голчлон оролцох учир хөрс үүсгэгч эх чулуулаг нь алюви, делюви, пролювийн хайрган хурдас дээр тогтвортжсон нимгэн ялзмагт давхартгатай, сайр чулуурхаг, нам ухаа толгод, уулын хөрс, тал газар, нам хөндий хотос газрын хөрс тархсан байна.

Ургамал: Хэнтийн нурууны чийглэг сэргүүн уур амьсгал, өндрийн бүс бүслүүр,.gov, тал хээрийн бүсийн ялгаагаар ургамлын бүрхэвч өндөр уулнаас нам хотос хүргэл нэлээд ялгаатай бүрэлдэн тогтсон ба ургамлын бүтэц бүрэлдэхүүн Хангайн бүсэд баялаг, тал хээрт ядмаг байдаг байна. Сав газар нь тундрын, ойн, хээрийн, нутын хэв шинжийн ургамалшилтай юм.

Нийгэм эдийн засаг: Заамар сум нь УБ хотоос 180 км өөрийн аймгаас 225 км алслагдан оршдог бөгөөд Төв аймгийн Угтаал, Цээл, Лүн сумд, Булган аймгийн Баяннуур, Бүрэгхангай сумд, Сэлэнгэ аймгийн Орхон туул сумдуудтай тус тус хиллэж нийт 280.3 мянган га нутаг дэвсгэрийг эзэлдэг.

Төв аймгийн баруун хойд хэсэгт: Улаанбаатар хотоос 180 км, Аймгийн төвөөс 225 км зайд байрладаг. Баруун талаараа Булган аймгийн Баяннуур Дашинчилэн сум, хойд талаараа Булган аймгийн Бүрэгхангай, Орхонтуул сум, Зүүн талаараа Төв аймгийн Цээл, Угтаал сум, Урд талаараа Төв аймгийн Баянхангай, Лүн сумдтай тус тус хиллэдэг.

Малын бүтэй: Сумын хэмжээнд 193631 толгой малтайгаас 170 тэмээ, 13788 адuu, 10674 үхэр, 94853 хонь, 74146 ямаа Сумын хэмжээгээр нийт 193,8 мянган мал тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 0,6 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 0,3 хувь байна. 437 малчин өрх, 650 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 67,2 хувийг эзэлж байна.

Орон нутгийн төсөв: Сумын төсвийн нийт орлого нь 4141,3 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн санхүүжилт авдаггүй, сумын өөрийн орлого 1261,9 сая төгрөг төсөвт байгууллагын өөрийн орлого 1.9 сая төгрөг байна. Орон нутгийн нийт төсвийн зардал нь 2058,0 сая төгрөг байна. Нийт зардлын 61.4 хувь нь цалин, 6.8 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, хувийг ургал шилжүүлэг болон бусад зардал эзэлж байна.

Эдийн засгийн бүтэц: Сумын хэмжээнд нийт 47 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 770,2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 30.6 сая, аймагт 203.4 сая, орон нутагт 56.0 сая нийт 209.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Тус суманд жилд 230,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Заамар довон” ХХК 2900 га эргэлтийн талбайтай, 800 га д уриншийн боловсруулалт хийж жилд 1200,0 тн үр тариа хураан авдаг бөгөөд БӨЖТ зэрэг аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлж байгаа нь тус сумын аж үйлдвэрийн бүтцэд томоохон нөлөө үзүүлж байна.

Сумын төвийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн өнөөгийн байдал: орон сууц, олон нийтийн бүс 1200 га ногоон байгууламж, хөдөө аж ахуйн бүс 240200 га хот суурингийн газар 81,0 га Өнөөгийн байдлаар 719 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 438 га газар өмчилж, 10 иргэн, аж ахуйн нэгж өвөлжөө, хаваржааны зориулалтаар 0,77 га газар, газар тариалангийн зориулалтаар 12700 га газар, 438 иргэн 8 аж ахуйн нэгж газар тариалангийн зориулалтаар эзэмшиж байна.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт №9.Болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй нөхцөлүүд
<p>Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: -Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх, -Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, эсэх.</p>	<p>Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос шороо болон хорт хий агаар орчныг бохирдуулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">✓ Хөрс хуулах, алт олборлох үед үүсэх тоос;✓ Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтат хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утая болон хорт хий, дуу чимээ;✓ Уурхайн олборлолт болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос;✓ Хөрс болон элс тээвэрлэх үед тээврийн хэрэгслийн дугуйнаас босох тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.
<p>Усан орчинд үзүүлэх нөлөөлөл: -Усны нөөцдөд хомсдол үүсэх, эсэх, -Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх, -Ус бохирдуулах, эсэх.</p>	Уурхай болон үйлдвэр технологийн хэрэгцээний усыг газрын доорх ус болон тунаах нуурын усаар хангана. Энэ тохиолдолд тунаах нуурын болон газрын доорх усны нөөцдөд тодорхой хэмжээний хомсдол үүсгэх болно.
<p>-Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө: -Хөрс эвдрэх эсэх, -Хөрс бохирдох эсэх, -Хөрс доройтох эсэх.</p>	Хөрсний морфологи бүтэц алдагдах, үржил шимт нөөц нь багасах, техногений нөлөөлөл ихсэж, олон салаа зам үүсч, хөрс эвдрэх, хөрс хийсэх, дарагдах, талхлагдах зэргээр шинж чанар нь өөрчлөгдөх, Хөрсний өнгөн хэсэг ахуйн хог болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох.
<p>-Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө: -Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх, -Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх.</p>	Газарт бууж буй тоос нь ургамлын аль нэг хэсэгт наалдаж улмаар өнгө зүс нь алдагдах, навч нь эрт унах зэрэг байдал бий болдог байна. Ургамлын бүрхүүлийн энэхүү өөрчлөлт нь хүний нүдэнд ил харагдаж байдаг бол үүний цаана нүдэнд харагдахгүй ихээхэн өөрчлөлт орох, фотосинтезийн идэвхи буурах, өсөлт удаашрах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих зэрэг байдал бий болдог.
<p>-Ан, амьтанд үзүүлэх нөлөө: -Амьтдын амьдрах орчинг доройтуулах эсэх, амьдрах орчинг үгүй хийх,</p>	Алт олборлох үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин устах, жижиг амьтад үйл ажиллагаанд өртөж үхэж хорогдох, хүний үйл ажиллагааны улмаас амьтдын бүлгэмдэлд өөрчлөлт орох, улмаар зарим зүйл амьтдын тоо толгой, нүүдэл шилжилтэнд сөргөөр нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөтэй.

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

“Ирмүүн босго” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлاغнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь Хайлаастын дэнжийн ХШ-45-75 хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ундны усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээ,
- ✓ Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих, хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- ✓ Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх,
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож, доор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэх.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан. Хуулийн дээрх шаардлагын дагуу Хайлаастын дэнжийн ХШ-45-75 хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бус нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт №10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Зардал 2025 он /төгрөг/	Гарах үр дүн	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
1	Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудад усалгаа хийх, ялангуяа хуурайшилттай хаврын улиралд тогтмол усалж байх, Олон салаа зам гаргахгүй байх	4-9 сард салхи, хуурайшилт ихтэй өдрүүдэд	“Ирмүүн босго” ХХК	3,000,000	Агаарын бохирдолоос сэргийлэх	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS5885:2008, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ -MNS ISO4227:2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 216 дугаар тушаал
2	Агаарын хяналт шинжилгээг тогтмол хийх	ОХШХ-т тусгагдсан	Байгаль орчны мэргэжилтэн	ОХШХ-т тусгагдсан.	Тоосжилтооссэргийлэх	
3	Машин техникийг оншилгоонд цаг тухайд нь хамруулж байх Мото цагийн үйлчилгээг тогтмол хийлгэх	Автомашин үзлэгт орох үед	“Ирмүүн босго” ХХК	2,000,000	Уурхайн сул зогсолтгүй үйл ажиллагаагаа явуулах боломжтой	
4	Шаардлагатай тохиолдолд хуучин тэмдэг тэмдэглээг сайжруулах, сэргээн засварлах	Шаардлагатай тохиолдолд	“Ирмүүн босго” ХХК	Үйл ажиллагааны зардал	Осол эрсдлээс урьдчилан сэргийлэх давуу талтай	
ХӨРСӨН БҮРХЭВЧ						
1	Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Уурхайн ажил эхлэхийн өмнө	Байгаль орчин, ХАБЭА ажилтан	1,500,000	Хөрс эвдрэлд орж, газрын тогтоц, хэлбэр, төрх өөрчлөгдхөөс сэргийлэх	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт MNS 3995 : 2010 Хөдөлгүүрийн тос Ангилал, тэмдэглэгээ MNS 5914 : 2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.
2	Засварын талбайд тос масло асгарч хөрс бохирдуулахаас сэргийлэх, хатуу хучилттай болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Уурхайн ажил эхлэхийн өмнө	“Ирмүүн босго” ХХК	500,000	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргилийэх	
3	Шимт хөрсний нөөц бий болгох стандартын дагуу овоолж, ургамалжуулах хадгалах	Хөрс хуулах ажлын шатанд	Шимт хөрсний овоолго	2,000,000	Шимт хөрсний чанар муу байх нь нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнгүй болгож экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	
4	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Осол аваарь гарч болзошгүй цэгүүд	“Ирмүүн босго” ХХК	1,000,000	Олон салаа зам гарахаас сэргийлнэ. Жолоочийн аваарь осолд өртөх эрсдэл багасна.	
АМЬТАН						
1	Ухсан нүх суваг, шуудуунд мал, амьтан унахаас сэргийлэх хараа хамгаалалтыг сайжруулах,	Уурхайн талбайд	Уурхайн удирдлага	1,000,000	Уурхайн талбайд мал, амьтан унаж гэмтэхээс сэргийлэх харуул хамгаалалт сайжруулах	Амьтны тухай хууль /2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр/

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Зардал 2025 он /төгрөг/	Гарах үр дүн	Баримтлах стандарт, аргачлал
2	Цахилгаан дамжуулах шугам, шон зэргийн ойролцоо шувуу үргээгч суурилуулах	Уурхайн талбайд	“Ирмүүн босго” ХХК	1,000,000	Шувууд өндөр хүчдэлийн тогонд цохиулах, бэртэж гэмтэх, үхэх зэрэг сөрөг нөлөөлөөс сэргийлэх	Ан агуулын тухай /2000 оны 05 дугаар сарын 05-ны өдөр / Байгаль орчны хамгаалах тухай хууль
УСАН ОРЧИН						
1	Туул голын сав газартай ус ашиглуулах гэрээ хийж, ус ашиглуулах дүгнэлт гаргуулж төлбөрийн цаг тухайд нь төлөх	Жилдээ нэг удаа	“Ирмүүн босго” ХХК	Үйл ажиллагааны зардлаар	Усны нөөц хомсдох, чанар муудахаас сэргийлэх	Усны тухай хууль, -MNS6148:2010, “Усны чанар. -MNS0900:2010 Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”,
2	Үнд ахуйн ус болон зам усалгааны усны дээж авчлaborаториор шинжлүүлэх	ОХШХ-т тусгагдсан	“Ирмүүн босго” ХХК	ОХШХ-т тусгагдсан		
НИЙТ ЗАРДАЛ					12,000,000	

1.2. Нохон сэргээлтийн төлөвлөгөө

Уурхай нь тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ашиглалтын системтэй. Дотоод овоолгоор хийгдэх техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардал нь үйлдвэрлэлийн зардалд орно.

2025 онд “Ирмүүн босго” ХХК нь MV-020868 тоот тусгай зөвшөөрлийн талбайд нэмэлт хайгуулын ажлыг гүйцэтгэж нөөцийг өсгөн цаашид уг талбайд үргэлжлүүлэн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа болно. Иймээс 2025 онд хаалтын ажлыг төлөвлөөгүй.

Хүснэгт № 11 Нохон сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн төрөл	Зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Техникийн нөхөн сэргээлт	28,000,000	2025
2	Биологийн нөхөн сэргээлт	14,500,000	
3	Нөхөн сэргээлт хийсэн газрыг хамгаалах ба мониторинг хийх зардал	3,700,000	
Нийт		46,200,000	

1.3. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Тус ордын ойр орчмын бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй.

“Ирмүүн босго” ХХК-ийн биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын

олон янзбайдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

1.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт №12.Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Талбайн хэмжээ	Зардал
1	Төв аймгийн Заамар сумын нутагт хууль бус гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй орхигдсон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг 2025 онд хийж гүйцэтгэнэ	2 га	2,000,000

1.6. Тэрбум мод төслийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих төслийн хүрээнд 500 ш мод тарьж ургуулах, арчлах ажлыг хийнэ.

Хүснэгт №13. Тэрбум мод тарих төслийн хүрээнд тарих модны тоо, зардал

№	Тарих мод бутны төрөл зүйл	Нийт
1	Бургас, Шар хуайс, Ухрийн нүд,	500 ш
2	Төсөвт өртөг	2,000,000 төгрөг

1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

"Ирмүүн босго" ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохигох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай

Хүснэгт №14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	<p>-Гамшигаас хамгаалах тухай хууль, 2003 (суулийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17), -MNS6010-2009</p> <p>Гамшигийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги, -MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага, -MNS 12.4. 005 – 1985: Хөдөлмөр хамгаалал. Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд.</p> <p>-Эрүүл мэндийн тухай хууль,</p>
2	Аваар устгах төлөвлөгөөг жил бүр батлуулж ажиллах	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	
3	Ажилчдыг ээлжинд гараахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	
4	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчидад	500,000	Жилд 1 удаа	
5	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Кемп орчимд	500,000	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
6	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахайц газруудад байрлуулах	Кемп орчимд	150,000	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
7	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардал	Тухай бүрт	
8	Ажиллагсдыг хөдөлмөр хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангах	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	
9	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчидад	Удирдлага зохион байгуулалтын зардлаар	Жилд 1 удаа	
10	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Уурхайн ажилчидад	Үйл ажиллагааны зардал	Жилд 1 удаа	
Нийт				2,050,000	

1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Уурхайд зориулалтын ахуйн хог хаягдлын сав байрлуулах	Хог хаягдал	500,000	Уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө	<p>-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага,</p>
2		Хог хаягдлыг төвлөрсөн нэг цэгт төвлөрүүлж, хог хаягдлын цэгийг гадна орчинд тархаж, салхинд хийсэхээс сэргийлж хашаажуулах, хамгаалах арга хэмжээ авах		200,000	Жилд 1 удаа	
3		Хог хаягдлыг орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулж, тухай бурт тээвэрлүүлэх		Үйл ажиллагааны зардал	Улиралд 1 удаа	-Ариун цэврийн тухай хууль,
4	Аюултай	Уурхайгаас гарсан ашигласан шатах тослох материалын үлдэгдэл, аюултай хог хаягдлыг зориулалтын саванд хадгалах, хуримтлуулах, газрын гадаргад асгарч алдагдахаас сэргийлэх	Аюултай хог хаягдал	Үйл ажиллагааны зардал	Уурхайн үйл ажиллагааны үед	<p>-Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль.</p>
5		Аюултай хог хаягдал, ашигласан шатах тослох материалын үлдэгдлийг аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх		Үйл ажиллагааны зардал	Жил бүр	
6	Шингэн	Ахуйн бохир шингэн хаягдлыг битүүмжлэл сайтай ёмкост хуримтлуулан бохир соруулах машинаар холбогдох газарт нийлүүлэх	Бие засах газар	750,000	Уурхайн үйл ажиллагааны үед	
7		Бохир ус хуримтлуулах сав буюу ёмкосыг нэвчилт шүүрэлт явагдахааргүй битүүмжлэл сайтай хийх		100,000	Улиралд 1 удаа	
Нийт				1,550,000		

1.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт №16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Үрьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Ажилчид	2,500,000	Жилд 1 удаа
2	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр хангах	Ажилчид	Үйл ажиллагааны зардал	Жилд 1 удаа
3	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн узлэгт хамруулах	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардал	Жилд 1 удаа

№	Үрьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
4	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгүүлэх	Мэргэжлийн байгууллага	5,000,000	5 жил тутамд
5	БОМТ-ний биелэлтийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь өгч байх	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардал	Жил бүр
6	Жил бүрийн БОМТ-г БОАЖЯ-аар хянуулан баталгаажуулах	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардал	Жил бүр
Нийт			7,500,000	

1.10. Олон нийтэд тайлагнах хувাарь, төлөвлөгөө

"Ирмүүн босго" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчинээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн нь төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт №17. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаанытов	Зохион байгуулах газар
Төв аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Уурхайд
	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Уулзалт			БОАЖЯ-ны ХБОБНУГ-т
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засагдарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон цахим хэлбэрээр	2025 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	Засаг даргын тамгын газарт

1.11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

"Хайлаастын дэнжийн ХШ-45-75" нэртэй алтны шороон ордыг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс үрьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээнэй зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

"Ирмүүн босго" ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллана.

Хүснэгт №18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ явуулах ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Хяналтын цэгийн байршил	Хяналтын хугацаа, давтамж	Зардал, 2025 он /тогрог/	Баримтлах стандарт, аргачлал
АГААРЫН ОРЧИН					
1	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ , CO -ын агууламж, Xүнд металл тодорхойлох Агаар орчны бохирдол агаар дахь цараг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Уурхайн ухаж ачих процессын үед, ажилчдын хотхон, уурхайн дотоод зам	Олборлолтын талбайд 3 цэгт жилд 2 удаа /хавар, зун/	600,000	-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорын авахад тавих ерөнхий шаардлага,
УСАН ОРЧИН					
1	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар) Цэвэр болон бохирын нуураас хүнд металлын шинжилгээ /As, U, Pb, W, Th, Sn, Nb, Se, Zn, Zr/	Худаг-1,2 Цэвэр болон бохирын нуураас-2	Усны ерөнхий химийн шинжилгээ Хими бактериологийн бүрэн шинжилгээ 1 цэгээс 2 удаа	480,000	-MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж -MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт.
ХӨРСӨН БҮРХЭВЧ					
1	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Xүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	Уурхайн шимт Хөрсний овоолго, Ахуйн бохир усны хаягдал орчимд, хотхон, засварын талбай	4 цэгт жилд 2 удаа	400,000	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга
НИЙТ ДҮН				1,480,000	

ДҮГНЭЛТ

“Ирмүүн босго” ХХК-ийн 2025 оны БОМТ-г БОНХЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа. 2025 онд БОМТ-нд нийт **74.78** сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт №19. 2025 оны БОМТ-ний нийт зардал

№	Арга хэмжээ	Зардал, 2025 он /төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12,000,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	46,200,000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,550,000
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,050,000
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1,480,000
5	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	7,500,000
6	Тэрбум мод тарих төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2,000,000
7	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	2,000,000
8	БОМТ-ний хэрэгжилтийг орон нутагт тайлагнах хуваарь	Үйл ажиллагааны зардал
Нийт дүн		74,780,000

“Ирмүүн босго” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлаастын дэнжийн ХШ-45-75 хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл нь өмнөх жилүүдэд бүрэн хүчин чадлаар ажиллаж чадаагүй, ордын нөөцийг бүрэн ашиглаж дуусаагүй байгаа тул 2025 онд уурхайн хаалт хийгдэхгүй. Иймд төслийн БОННҮ-ний тайлангийн хаалтын өмнөх жилийн менежментийн төлөвлөгөөг уртала болгон 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

“Ирмүүн босго” ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах дүгнэлтэнд хүрлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 74,780,000 төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 50% –ийг нь Байгаль орчин, нөхөн сэргээх баталгааны дансанд байршуулах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.